



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.08.27 № 1323
танай _____-ны № _____-т

**НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР
ДЭВШИХ ИРГЭН
Ш.НАРАНГАРВУУ ТАНАА**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвших иргэн Шурагийн Нарангарвуугийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэн нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтод нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлэн хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэний сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа 2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Иргэн Шурагийн Нарангарвуугийн нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвшихээр ирүүлсэн сонгуулийн


мөрийн хөтөлбөр, түүнд тусгагдсан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэн Шурагийн Нарангарвуугийн сонгуулийн мөрийн хөтөлбөр (3 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Нийслэлийн Сонгуулийн хороонд

Хавсралт: 3 хуудастай

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НОМИНБААТАР



**НИТХ-ЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧИЙН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Бие даан нэр дэвшигч: Ш.Нарангарвуу

Монгол улсын хүн амын 1/3-н ажиллаж амьдарч, нийт эдийн засгийн 65%-ийг бий болгож буй их хотыг илүү хурдтай, илүү тулхтай хөгжүүлэх боломж байсаар байна. Асуудлын гол мөн чанар нь бизнесийн орчныг илүү таатай болгох, илүү нээлттэй болгох бөгөөд үр дүнд нь мянган бизнес шинээр бий болж, түүнийг дагасан хөрөнгө оруулалт ихээр орж ирж, улмаар хэдэн зуун мянган өндөр цалинтай ажлын байр бий болно.

Бид юунаас эхлэх вэ?

1. Нийслэлд бизнес эрхлэх боломжуудыг тодорхойлно. Ингэхдээ бага, дунд, том, мега түвшинд ангилж, суурь судалгааны ажлуудыг эхний ээлжид хийнэ.
2. Бизнесийг бодлогоор хөгжүүлэх концепцийн судалгааны ажлыг хийнэ.
3. Бизнесийг кластераар хөгжүүлэх концепц тодорхойлж, байршлын судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэнэ.
4. Бизнес кластерын бизнес моделуудыг боловсруулна. Үүнд: Эдийн засгийн чөлөөт бүс, Үйлдвэр технологийн парк зэргийн үзэл баримтлал боловсруулан олон улсын хөрөнгө оруулагчдыг татах хэмжээнд гадаадын төсөл хөтөлбөр, зөвлөх компаниудын дэмжлэгтэйгээр техник, эдийн засгийн үндэслэл боловсруулна.
5. Дэлхийн түвшний шилдэг их, дээд сургуулиудын салбарыг Улаанбаатарт байгуулах гэрээ хэлцэл хийж, газар болон бодлогоор дэмжин хөрөнгө оруулалт татах ажлыг хийнэ.
6. Дотоодын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг бодлогоор дэмжих, чиглүүлэх ажлыг шат дараатай шийдвэрлэх, МСҮТ-үүдэд хөрөнгө оруулалт татах, сургалтын агуулга, орчин, материаллаг баазыг сайжруулах чиглэлд холбогдох яамтай хамтран ажиллана.
7. Нийслэлийн бизнесийн орчныг сайжруулах чиглэлд бусад орны нийслэл хотуудтай хамтран ажиллах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг судлан ажиллана.

Бие даан нэр дэвшигч Ш.Нарангарвуу



8. Нийслэл хотод хэрэгжиж буй олон улсын төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллаж, Нийслэлээс хэрэгжүүлэх төсөл хөтөлбөртэй уялдуулж, хамтран ажиллана.
9. Нийслэл хотод органик ферм хөгжүүлэх суурь судалгааны ажлыг хийнэ.

Бид юунд анхаарах вэ?

1. Ирээдүйд эрэлттэй мэргэжлийн жагсаалт гарган мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх тал дээр их дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдтэй хамтран ажиллана.
2. Гадаад дотоодын хөрөнгө оруулагчдыг татах чиглэлд ажиллана.
3. Салбарын эрдэмтэн судлаачид, доктор профессоруудтай хамтран ажиллаж, төслүүдийн суурь судалгаа, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, тэдгээрийн ажлын даалгаврыг шинжлэх ухааны үндэстэй боловсруулах ажлыг хийнэ.
4. Салбар хоорондын уялдааг хангах чиглэлд нийслэлийн болон салбарын яам, түүний харьяа агентлагийн түвшинд хамтын ажиллагаа өрнүүлнэ.
5. Авилга, албан тушаалын зөрчлөөс ангид байх чиглэлд анхаарч, нээлттэй засаглалыг хөгжүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн кодыг тодорхой болгож, хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлд бодит алхам хийнэ.
6. Төрийн албан хаагчдыг чадавхжуулах, мэргэжил дээшлүүлэх, хувь хүнийн хөгжил, хандлагыг дээшлүүлэх чиглэлээр тасралтгүй сургалт, хөгжлийн ажлыг зохион байгуулна.
7. Төрийн албаны нэр хүндийг сэргээх, төрийн албаны залгамж чанар, тасралтгүй тогтвортой ажиллах бодлогыг боловсруулан хэрэгжүүлнэ.

Бид ямар үр дүнд хүрэх вэ?

1. Нийслэлд хэрэгжүүлэх бүх ажил шинжлэх ухааны үндэслэлтэй хэрэгжих суурь нөхцөл бүрдэнэ.
2. Төрийн албан хаагчдын чадавх сайжирна. Ёс зүй, хариуцлага дээшилсэн байна.
3. Төр иргэддээ үйлчилдэг бодит харилцаа үүссэн байна.
4. Төрийн үйл ажиллагаа авилга, ашиг сонирхлоос ангид байж хүнд суртал арилна.

Бие даан нэр дэвшигч Ш.Нарангарвуу



5. Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа дээшилж, үргүй зардал, хийдэл, давхардал арилна.
6. Нийслэл хотын хэмжээнд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний эрэмбэ зөв үүсэж, хамгийн чухал ажлуудаас ажлаа эхлэх боломж бүрдсэн байна.
7. Нийслэл Улаанбаатар эдийн засаг, үйлдвэрлэлийн төв болох бодит алхам хийгдсэн байна.
8. Гадаад дотоодын хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалт хийх боломж, мэдээллийн сан бүрдсэн байна.
9. Улаанбаатарт бизнесийг кластераар хөгжүүлэх нөхцөл бүрдсэн, бүтээгдэхүүний үнэ цэнийн холхоо буюу нэмүү ортгийн сүлжээ үүссэн байна.
10. Нийслэлд бизнес эрхлэх таатай орчин бүрдэж, бизнесийн зөв загварчлал бий болсон байна.
11. Төр болон хувийн хэвшил, мэргэжлийн холбоод хамтран ажиллах бодит боломж бүрдсэн байна.

Бие даан нэр дэвшигч Ш.Нарангарвуу 

